



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бигэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/55/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд	
	Утас: 99177546	Цахим хаяг: Buujinkhandj@audit.gov.mn
	Аудитор	Г.Энхдэлгэр
	Утас: 70484030	Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 62
танай _____ -ны № _____ -т

БИГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА И.САЙНЖАРГАЛ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Бигэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Бигэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Татварын тодорхойлолтоор зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй, жилийн эцсийн тооллогоор шатахууны үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, бодитоор байгаа эсэх нь тодорхойгүй, бүртгэлийн программд эмийг нэр төрлөөр бус харилцагч байгууллагын бөөн дүнгээр эмийг орлого авч зарлагадсан зэрэг 248.9 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаал, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07020338

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	92,154,870.70	320,157,439.30
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	51,323,372.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	51,323,372.00
3121	Төгрөг	-	51,323,372.00
31211	Төрийн сангийн харилцах	-	50,916,758.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	406,614.00
33	АВЛАГА	322,958.00	143,905,800.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	322,958.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	143,905,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	91,831,912.70	120,028,267.30
351	Түүхий эд материал	19,045,859.70	39,273,529.70
35130	Эм боох материал	19,045,859.70	39,273,529.70
354	Хангамжийн материал	72,786,053.00	80,754,737.60
35410	Бичиг хэргийн материал	1,017,100.00	1,806,650.00
35420	Аж ахуйн материал	54,191,225.00	68,842,000.60
35440	Түлш шатах тослох материал	13,474,210.00	6,312,225.00
35460	Хүнсний материал	4,103,518.00	3,793,862.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	4,900,000.00
36400	Шатахууны нөөц	-	4,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	806,139,411.06	803,435,071.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	806,139,411.06	803,435,071.55
392	Биет хөрөнгө	794,239,411.06	791,535,071.55
39201	Барилга, байгууламж	505,188,091.00	505,188,091.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(15,734,506.88)	(24,168,389.12)
39203	Авто тээврийн хэрэгсэл	79,500,000.00	68,274,355.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(58,150,000.22)	(47,797,542.94)
39205	Машин, тоног төхөөрөмж	538,479,299.50	599,981,982.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(272,783,610.56)	(335,300,570.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,835,078.00	48,175,078.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,229,523.10)	(28,379,515.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,230,000.00	5,980,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(107,666.68)	(430,666.72)
39217	Номын фонд	12,250.00	12,250.00
393	Биет бус хөрөнгө	11,900,000.00	11,900,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хасагдуулга	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,900,000.00	11,900,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	898,294,281.76	1,123,592,510.85
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	898,294,281.76	1,123,592,510.85
51	Засгийн газрын хувь оролцоо	898,294,281.76	1,123,592,510.85
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	700,631,831.50	700,631,831.50
51101	Өмч: -Төрийн өмч	652,273,203.00	652,273,203.00
51102	-Хувийн	48,358,628.50	48,358,628.50
512	Хуримтлагдсан үр дүн	191,462,476.21	416,760,705.30
51210	Өмнөх үеийн үр дүн	191,462,476.21	191,462,476.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	225,298,229.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,199,974.05	6,199,974.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	898,294,281.76	1,123,592,510.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗТЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	566,448,207.54	1,135,883,503.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,069,611.54	224,779,241.93
120	Нийтлэг татварын бус орлого	10,069,611.54	224,779,241.93
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,069,611.54	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,069,611.54	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	54,994,138.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	169,785,103.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	556,378,596.00	329,424,762.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	538,084,100.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	538,084,100.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	581,679,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,081,350.00	306,980,013.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	158,500.00	182,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвө	8,211,550.00	40,177,913.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт ор	711,300.00	5,055,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	261,565,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	14,640,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	14,640,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	9,213,146.00	7,804,749.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас	9,213,146.00	7,804,749.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	569,775,418.13	910,585,274.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	569,775,418.13	910,585,274.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	549,054,699.13	863,625,087.84
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	375,814,063.00	408,332,012.00
210101	Цалин	245,358,266.00	271,047,299.00
210102	Нэмэгдэл цалин	89,854,550.00	76,421,389.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,947,991.00	6,146,000.00
210104	Урамшуулал	32,653,256.00	35,590,445.00
210105	Гэрээтийн цалин	-	19,126,879.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,659,123.00	54,082,942.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	31,451,223.00	37,442,942.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,052,000.00	4,160,000.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,241,600.00	3,328,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	810,400.00	832,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	8,103,900.00	8,320,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,756,697.00	12,685,038.00
210301	Гэрэл цахилгааны зардал	2,250,000.00	2,500,000.00
210302	Түлш, халаалтын зардал	9,506,697.00	9,910,038.00
210303	Цэвэр, бохир усны зардал	-	275,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,420,500.00	37,227,451.00
210401	Бичиг хэргийн материал	1,394,750.00	1,083,100.00
210402	Тээвэр, шатахууны зардал	14,008,050.00	20,153,572.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,188,750.00	1,746,400.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,388,750.00	12,804,979.00
210406	Бага үнэ тургэн элэгдэл зүйлс	1,440,200.00	1,439,400.00
2105	Нормативт зардал	42,190,693.84	257,733,710.33
210501	Эм	31,941,517.84	220,640,934.33
210502	Хоол	6,720,501.00	12,813,776.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,528,675.00	24,279,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,549,489.00	4,021,500.00
210601	Багаж хэрэгсэл	1,303,489.00	22,500.00
210604	Урсгал засвар	3,246,000.00	3,999,000.00
2107	Томилголт, зочны зардал	532,000.00	537,057.00
210702	Дотоод томилголын зардал	532,000.00	537,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,388,850.00	4,201,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хура	868,000.00	3,132,500.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	714,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	54,450.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,000.00	75,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	59,500.00	59,500.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	551,400.00	846,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,743,283.29	84,803,977.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,488,750.00	1,532,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,254,533.29	83,271,377.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,720,719.00	46,960,187.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,068,900.00	46,730,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	3,068,900.00	46,730,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,651,819.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,651,819.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгож татаас, санхүүжилт	-	230,187.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	230,187.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	(3,327,210.59)	225,298,229.09
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	13,832,302.64	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,832,302.64	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI-IV-V)	(13,832,302.64)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII-III+VI)	(17,159,513.23)	225,298,229.09

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл				
3	Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
9	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	700,631,831.50	6,199,974.05	191,462,476.21	898,294,281.76
10	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	700,631,831.50	6,199,974.05	191,462,476.21	898,294,281.76
11	Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	700,631,831.50	6,199,974.05	191,462,476.21	898,294,281.76
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			225,298,229.09	225,298,229.09
18	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	700,631,831.50	6,199,974.05	416,760,705.30	1,123,592,510.85

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	556,490,996.00	767,521,420.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,400.00	322,958.00
120	Нийтлэг татварын бус орлого	112,400.00	322,958.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	112,400.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	112,400.00	-
120009	Бусад орлого	-	322,958.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	556,378,596.00	767,198,462.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	538,084,100.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	538,084,100.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	581,679,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,081,350.00	163,074,213.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгэдээс авсан хандив тусламж	158,500.00	182,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төс	8,211,550.00	40,177,913.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хурээнд бий болсон нэмэлт	711,300.00	5,055,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	117,659,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	14,640,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	14,640,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,213,146.00	7,804,749.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,213,146.00	7,804,749.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	540,105,996.00	690,625,148.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540,105,996.00	690,625,148.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	519,080,777.00	643,064,961.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	375,814,063.00	408,332,012.00
210101	Үндсэн цалин	245,358,286.00	271,047,299.00
210102	Нэмэгдэл	89,854,550.00	76,421,389.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,947,991.00	6,146,000.00
210104	Үр дүнгийн урамшуулал	32,653,256.00	35,590,445.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	19,126,879.00
2102	Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,659,123.00	54,062,942.00
210201	Тэтгэрийн даатгалын шимтгэл	31,451,223.00	37,442,942.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,052,000.00	4,160,000.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,241,600.00	3,328,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	810,400.00	832,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	8,103,900.00	8,320,000.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	12,751,947.00	12,477,813.00
210301	Гэрэл цахилгааны зардал	2,250,000.00	2,500,000.00
210302	Түлш, халаалтын зардал	10,501,947.00	9,702,813.00
210303	Цэвэр, бохир усны зардал	-	275,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,452,520.00	27,087,912.00
210401	Бичиг хэргэ	1,444,000.00	1,375,200.00
210402	Тэвэр, шалтхуун	17,803,170.00	18,098,812.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,188,750.00	1,746,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,050,000.00	4,922,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,966,600.00	945,000.00
2105	Нормативт зардал	43,962,524.00	127,433,155.00
210501	Эм бэгдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,799,574.00	87,986,685.00
210502	Хоол, хүнс	8,182,450.00	12,117,870.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,980,500.00	27,328,600.00
2106	Эд хялшил, урсгал зэвсэрийн зардал	5,121,400.00	6,847,700.00
210601	Багаж техник хэрэгсэл	2,246,400.00	4,915,700.00
210604	Урсгал засвар	2,875,000.00	1,932,000.00
2107	Томиллолт, зочны зардал	532,000.00	537,057.00
210702	Дотоод албан томиллолт	532,000.00	537,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,787,450.00	4,698,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	868,000.00	3,132,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	714,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,000.00	75,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	59,500.00	59,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	950,000.00	1,344,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,999,750.00	2,167,520.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,999,750.00	2,167,520.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,025,219.00	46,960,187.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,373,400.00	46,730,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шалгалт урамшуулал	3,373,400.00	46,730,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,651,819.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,651,819.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	230,187.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	230,187.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	16,385,000.00	76,896,272.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,385,000.00	25,572,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,385,000.00	25,572,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,385,000.00	25,572,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,385,000.00	25,572,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(16,385,000.00)	(25,572,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	51,323,372.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	51,323,372.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Цэвэр гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	608,526,100.0	553,300,262.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	608,526,100.0	545,770,262.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,070,000.0	378,853,506.00
210101	Үндсэн цалин	244,000,000.0	241,568,793.00
210102	Нэмэгдэл	107,470,000.0	76,421,389.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,500,000.0	6,146,000.00
210104	Урамшуулал	35,600,000.0	35,590,445.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,500,000.0	19,126,879.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,916,000.0	50,311,476.00
210201	Тэтгэврийн даатгал	40,052,000.0	33,671,476.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,216,000.0	4,160,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,372,800.0	3,328,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	843,200.0	832,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,432,000.0	8,320,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,640,000.0	12,477,813.00
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.0	2,500,000.00
210302	Түлш, халаалт	9,865,000.0	9,702,813.00
210303	Цэвэр, бохир ус	275,000.0	275,000.00
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	31,294,200.0	28,934,712.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.0	1,222,000.00
210402	Тээвэр, шат ахуун	18,924,200.0	18,098,812.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,170,000.0	1,746,400.00
210404	Ном, хэвлэл	200,000.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хорт он мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.0	2,922,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ажуйн эд зүйлс	5,000,000.0	4,945,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
2105	Нормативт зардал	45,661,700.0	42,872,285.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,161,700.0	28,030,565.00
210502	Хоол, хүнс	8,500,000.0	7,850,120.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,000,000.0	6,991,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,614,100.0	28,420,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,614,100.0	26,488,600.00
210604	Урсгал засвар	2,000,000.0	1,932,000.00
2107	Томилголт, зочны зардал	1,500,000.0	198,000.00
210702	Дотод албан томилголт	1,500,000.0	198,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,394,000.0	2,168,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.0	602,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.0	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.0	75,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.0	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264,000.0	-
210807	Газрын төлбөр	80,000.0	59,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,000.0	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,000.0	1,344,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,906,100.0	1,533,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,906,100.0	1,533,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,530,000.00	7,530,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,530,000.0	7,530,000.00
213209	Нэг удаагийн этгэмж, шагнал урамшуулал	7,530,000.0	7,530,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	608,526,100.0	604,217,020.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	581,679,500.0	581,679,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	581,679,500.0	581,679,500.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,640,000.0	14,409,813.00
132001	Орон нутгийн төсвөөс	14,640,000.0	14,409,813.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,206,600.0	7,804,749.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,206,600.0	7,804,749.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	322,958.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	322,958.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		50,916,768.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	162,667,599.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	162,667,599.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	123,467,599.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	29,478,506.00
210101	Үндсэн цалин		29,478,506.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	3,771,466.00
210201	Тэтгэврийн даатгал		3,771,466.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,153,200.00
210401	Бичиг хэрэг		153,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		2,000,000.00
2105	Нормативт зардал	-	84,560,870.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		59,956,120.00
210502	Хоол, хүнс		4,267,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		20,337,000.00
2107	Томиллолт, зочны зардал	-	339,057.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		339,057.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,530,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,530,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	634,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		634,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	39,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	39,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		39,200,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	163,074,213.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	163,074,213.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	182,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	40,177,913.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,055,000.00
131106	Төсвийн урамшуулал	-	117,659,200.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	406,614.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Бигэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явуулдаг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 570.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 910.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 14.6 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25 хувиар буюу 225.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 124.9 сая төгрөг болж 33.1 сая төгрөгөөр өссөн нь ковид 19 вирусын тархалтын үед хүлээн авсан эм, эмнэлгийн хэрэгсэл, түүний зарцуулалттай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 170.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 169.8 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 307.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 124.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,240.1 сая төгрөг болж 60.4 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 25.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 55.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 20.2 сая төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна. Оны эцэст 1,240.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэлд Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос авах татаас санхүүжилтын 143.9 сая төгрөгийн авлага үүссэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,123.6 сая төгрөг болж 225.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 416.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 608.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс санхүүжүүлэхээр 581.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 14.6 сая төгрөг, ЭМД-ын сангаас 12.6 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 581.7 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 14.6 сая төгрөг, ЭМД-ын сангаас 7.8 сая төгрөгийн санхүүжилт

авч, урсгал үйл ажиллагаанд 553.3 сая төгрөгийг зарцуулж, орон нутгийн санхүүжилтээс 0.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 553.3 сая төгрөг буюу 91 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 38.2 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 6.6 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.2 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2.4 сая төгрөгөөр, нормативт зардлыг 2.8 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.2 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 1.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2.2 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 1.4 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 163.1 сая төгрөгийн санхүүжилт орж, урсгал зардалд 162.7 сая төгрөгийг зарцуулж, 0.4 сая төгрөгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын санхүүгийн тайлан болон татварын цахим систем дэх татварын өглөг, авлагын тооцооллыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 169 мэдээллээс 166 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 134.5 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 26.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй багаж техник хэрэгслийн зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 20.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тээвэр шатахууны зарцуулалт, эмийн нэр төрлийн тайланг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 277.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.1 сая төгрөгийн алдааг залруулж, 4.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 270.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад татварын цахим систем дэх татварын тооцооллын 2.1 сая төгрөгийн зөрүүг засварлуулсан.

4.2 Төлбөрийн акт

Жилийн эцсийн тооллогоор 4.9 сая төгрөгийн шатахууны үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, бодитоор байгаа эсэх нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Татварын тодорхойлолтоор 3.1 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 26.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй багаж техник хэрэгслийн зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Бүртгэлийн программд эмийг нэр төрлөөр бус харилцагч байгууллагын бөөн дүнгээр 240.9 сая төгрөгийн эмийг орлого авч 220.6 сая төгрөгийн эм зарлагадсан нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаал "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-тай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 134.5 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Бигэр сумын Эрүүл мэндийн төв	6	277.6	1	2.1	1	4.9	3	270.6	1	0